

**“ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ, ТЭМЦЭХ СЭРГИЙЛЭХ” АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ
/ЭХ НЯРАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ/**

2025 оны 06 сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Төсөвлөсөн/ Зарцуулсан төсөв, эх үүсвэр (сая төг)	Суурь түвшин		2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэг- жилтийн хувь
			Он	Түвшин			
Зорилт 1. Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах, ирээдүйн сорилтыг даван туулах арга замыг тодорхойлоход олон салбарын оролцоог хангах, халдварт өвчнөөс сэргийлэх, тандах, хяналт тавих нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар халдварт өвчний тохиолдлыг тогтвортой бууруулж, тархалтыг таслан зогсооход оршино.							
1.1	Халдварт өвчнөөс сэргийлэх, тандах, хяналт тавих үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах	2.0	2025	80	Халдварт өвчнөөс сэргийлэх тандах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	Томуу томуу төст өвчин болон амьсгалын замын халдварт өвчний дэгдэлтийн үед яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж хүүхдийн яаралтай тусламжийн тасаг, амьсгалын замын цочмог эмгэг судлалын тасгуудыг ажиллуулж байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн “Томуу, томуу төст өвчний идэвхжилийн үед хүүхэд, сувилахуйн тусламж, үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” А/145 дугаар тушаалын дагуу 2024 оны 12-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 04-р сарын 01-ны өдөр хүртэл нэмэлтээр ажиллах Хүүхэд судлалын үндсэн мэргэшлийн резидент эмч, бусад албадын ажилчид нэмэлтээр ажилласан.	70
1.2	Халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож бэлэн байдал, хариу	0	2025	85	Хүүхдийн байгууллага, хаалттай орчин	Халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор нүхэн жорлон болон ахуйн хог хаягдал, мал амьтны сэг зэмээс үүдэлтэй өвчин үүсгэгч нян шар усны үерээр зөөвөрлөгдөн ундны усыг бохирдуулан	60

	арга хэмжээний тогтвортой байдлыг хангах				(цэргийн хуаран, асрамжийн газар, хорих газар ...)-д халдварт өвчний тандалтын заавар боловсруулж, батлуулсан байна.	халдварт өвчин үүсгэх эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн заавар зөвлөмж постер мэдээллийг төвийн пейж хуудас болон веб сайтад байршуулан хүргэсэн. Амбулаторын мэдээллийн дэлгэцүүдээр эрүүл мэндийн боловсрол олгох богино видео шторкуудыг бэлтгэн хүргэхээс гадна холбогдох байгууллагуудын зөвлөмжүүдийг олон удаагийн давтамжтай хүргэж байна. Мөн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын эрүүл ахуй, ундны ус, хүнсний аюулгүй байдлын хадгалалт, зааврын талаар постер мэдээлэл пейж хуудас веб сайтаар дамжуулан хүргэснээс гадна амбулаторын зурагт дэлгэцүүдээр видео зөвлөмж байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага бэлтгэн төвийн амбулатороор үйлчлүүлж буй 3500 иргэдэд мэдээлэл хүргэн зөвлөмж тараасан. 2025 оны эхний хагас жилд 5 удаа зохион байгуулж нийт 1200 хүн, сургалт сурталчилгааг нийт 42 удаа зохион байгуулж 9800 гаруй хүн хамруулж нийт 2500 ш боршур тараасан байна. Өөрийн фэйсбүүк хаяг болон 21-р хорооны оршин суугчдын групп дээр нийт 20 удаа мэдээлэл тавьж 18900 гаруй хандалт авсан байна.	
Зорилт 2. Дархлаажуулалтын хууль эрх зүйн орчныг шинэчилж, анхан шатны тусламж үйлчилгээнд тулгуурласан дархлаажуулалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, хэнийг ч орхигдуулахгүйгээр хамруулах боломжийг бүрдүүлэх							
2.1	Вакцины хадгалалт тээвэрлэлт, чанар аюулгүй байдлыг хангах	-	2025	100	Вакцины зохистой менежментийн үнэлгээ хийх, эмнэлгийн тоног	Вакцины хадгалалт, чанар аюулгүй байдлыг ЭМС-ын 261-р тоот тушаалын дагуу бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. ЭНЭҮТ нь төрсний дараах 24 цагийн дотор хийгдэх нярайн • Саагийн вакцин • В гепатитын вакцин	100

					төхөөрөмжийн инженер, техникийн ажилтныг сургасан байна.	- Сүрьеэгийн вакциныг товллолын дагуу хийж гүйцэтгэж байна. - Нэмэлтээр улирлын томуугийн вакциныг эмч эмнэлгийн мэргэжилтнүүддээ хийж дархлаажуулсан Сар бүрийн эхний долоо хоногт ХӨСҮТ-өөс товллолын дагуу хийгдэх вакцины татан авалтаа хийдэг. ЭМС-ын А/189 тоот тушаалыг мөрдөж хүйтэн хэлхээний дамжлагаар зөөвөрлөж хадгалж байна. Вакцины хадгалалт тээвэрлэлт, чанар аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.	
2.2	Дархлаажуулалтын цахим бүртгэлийг сайжруулах	6.0	2025	100	Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтын мэдээнд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд УППСАЛА олон улсын байгууллагад мэдээлсэн байна.	2025 оны 05 сарын байдлаар нийт 1551 нярайд 24 цагийн дотор Сүрьеэ БЦЖ, В гепатит, Халдварт Саа эсрэг дархлаажуулалтад хамруулсан байна. Дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд бүрийг www.e-hospital.mn сайтад программд шивэлт хийж урьд оныхоос амжилттай ажиллаж байна. Дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд 100% шивэлт хийгдсэн.	100
Зорилт 3. Олон нийт, иргэний нийгмийн оролцоотой сүрьеэгийн цогц, чанартай тусламж үйлчилгээг хүн амд тасралтгүй хүртээмжтэй хүргэж, 2030 онд сүрьеэгийн халдварын тархалтыг таслан зогсоох дэлхийн стратегийн зорилтын биелэлтийг хангах							
3.1	ХДХВ-ийн халдвартай хүнд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хүртээмжтэй тогтвортой хүргэх	-	2025	90	Эрүүл мэндийн тусламжийг хүртээмжтэй хүргэнэ	ХДХВ-ийн халдвартай хүнд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хүртээмжтэй тогтвортой хүргэх Төвийн ерөнхий Захирлын журмыг мөрдөн ажиллаж байна.	100

3.2	Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулах	-	2025	90	Иргэдэд сурталчилгаа зохион байгуулна.	"Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг 03-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Амбулаторийн дэлгэцээр "Сүрьеэгийн хавдраас урьдчилан сэргийлэх" видео контент бэлтгэн олон удаагийн давтамжтай үйлчлүүлэгч нарт хүргэсэн. Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн эмэгтэйчүүдийн тасаг, төрсний дараах хэвтэн эмчлүүлж буй иргэдэд сүрьеэгээс урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий 1800 гаруй ширхэг гарын авлагыг тараан ажилласан. Төвийн 4 дэлгэцээр сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж видео контент байршуулж олон удаагийн давтамжтай үйлчлүүлэгч нарт хүргэн ажилласан.	100
-----	---	---	------	----	--	--	-----

Зорилт 4. Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирусийн халдвараас сэргийлэх, эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх, "иргэн төв"-тэй эрүүл мэндийн цогц, чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, халдварын тархалтыг бууруулах

4.1	Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В,С вирусын халдвар дамжихаас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	2025	98	Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 31-ний А/614 тоот тушаал "Эхээс хүүхдэд ХДХВ, тэмбүү, гепатитын В вирусийн халдвар дамжихыг зогсоох журам"-ын	ХДХВ, тэмбүү, гепатитын В,С вирусын халдвартай эхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ эмч эмнэлгийн мэргэжилтнүүд халдвар хамгааллын дэглэмээ барьж тусгай багаж тоног төхөөрөмж ашигладаг. В гепатитын халдвартай эхээс төрсөн хүүхдэд 12 цагийн дотор ГВВ эсрэг дархлаажуулалтын вакцин болон ГВВ эсрэг иммуноглобулиныг нэг өдөр зэрэг хийж байна. • Жирэмсний хяналтанд анх үзүүлэхэд • Жирэмсний 28 долоо хоногтойд • Үр хөндүүлэх, бусад мэс ажилбарт орох үед • Жирэмсний хожуу хугацаанд зулбасан үед	100
-----	--	---	------	----	--	--	-----

					хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийсэн байна.	Жирэмсний хяналтгүй ийлдэс судлалын шинжилгээг товллын дагуу хийлгээгүй тохиолдолд төрөх үед ХДХВ тэмбүү өвчнийг илрүүлэх түргэвчилсэн сорилыг авдаг. Хариу эерэг гарсан тохиолдолд дараагийн шатны байгууллага руу шинжилгээг илгээж хариуг баталгаажуулдаг. 2025 оны хугацаанд нийт ХДХВ-ийн 4 сэжигтэй тохиолдлын шинжилгээг ХӨСҮТ-рүү зөөж хариуг үгүйсгэсэн.	
4.2	ДОХ-той тэмцэх дэлхийн өдрийг угтаж сурталчилгаа зохион байгуулах	-	2025	80	Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлсэн байна.	ДОХ-той тэмцэх дэлхийн өдрийг 12-р сард тэмдэглэн өнгөрүүлэхээр төлөвлөсөн.	-
4.3	Үйлчлүүлэгч нарт ХДХВ-ийн халдвараас сэргийлэх ухуулга, сурталчилгааг зохион байгуулах	-	2025	90	Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг хийсэн байна. Нөлөөллийн уулзалтыг зохион байгуулж, үр дүнг танилцуулсан байна.	ХДХВ-ийн халдвараас сэргийлэх сургалтыг нийт 7 удаа зохион байгуулж 950 хүнд сургалт сурталчилгааг 32 удаа зохион байгуулж 8420 гаруй хүн хамруулж нийт 3000 ширхэг сурталчилгааны материал тараасан байна. Сурталчилгааны нөлөөллийн цуврал интервенцийг сар бүрийн давтамжтайгаар 9 удаа шинэчлэн байршуулсан. ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп ➤ Нисэх, яармаг оршин суугчдын групп	70

						зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 42120 хүн хандалт хийсэн.	
Зорилт 5. Зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх, тандах, хяналт тавих нэгдсэн тогтолцоог “Нэг эрүүл мэнд” зарчимд тулгуурлан боловсронгуй болгож, эрсдэл, тархалтыг бууруулах							
5.1	Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	-	2025	75	Зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтад дэмжлэгт хяналт хийх гарын авлага боловсруулсан байна.	Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг дараах байдлаар цахимаар мэдээлэл хүргэн ажиллаж байна. Сурталчилгааны нөлөөллийн цуврал мэдээллийг сар бүрийн давтамжтайгаар 4 удаа шинэчлэн байршуулсан. ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 13750 хүн хандалт хийсэн.	70
5.2	Хачгаар дамжих халдвар, хумхаа өвчнийг эрт илрүүлэх сургалт сурталчилгааны ажлууд хийх	-	2025	70	Хачгаар дамжих халдвараас сэргийлэх гарын авлага боловсруулсан байна.	Хачгаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх сургалтыг 4 болон 5-р саруудад нийт 5 удаа зохион байгуулж нийт 950 хүн, сурталчилгаа 28 удаа зохион байгуулж нийт 2500 ширхэг тараах материал бэлтгэн тараасан байна. Дараах цахим хуудсууд дээр 11 удаа мэдээлэл байршуулсан.Үүнд: ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв,	90

						➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 11280 хүн хандалт хийсэн.	
5.3	Зоонозын өвчний хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтныг чадавхижуулах	-	2025	50	Эмч мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулсан байна.	Зооноз өвчин судлалын үндэсний төвтэй хамтран халдвар судлаач 1 эмчийг сургалтанд хамруулсан.	50
Зорилт 6. Халдварт өвчний оношилгоонд лабораторийн орчин үеийн дэвшилтэт техник технологи, инновацийг нэвтрүүлсэнээр болзошгүй цар тахал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын тандалт, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлэх							
6.1	Халдварт өвчнийг илрүүлэх, тандах,, оношлох лабораторийн чадавхийг үнэлэх	5.0	2025	50	Лабораторийн чадавхыг үе шаттай үнэлж, дүгнэлт, зөвлөмж гарган хэрэгжилтийг хянасан байна.	Тайлангийн хугацаанд: Клиник биохимийн лабораторид нийт – 84688 шинжилгээ хийгдсэн байна. Үүнд: • ЦДШ (15-38 үзүүлэлт) – 28142 • Биохими (8-25 үзүүлэлт) – 21844 • ШЕШ, ШДШ (13,19 үзүүлэлт) – 13485 • Цус бүлэгнэлт – 6270 • Цусны бүлэг – 4050 • Цусаар дамжих халдвар – 5827 хүнд • Серологийн шинжилгээ – 527 • Иммунологийн шинжилгээ – 3927 • Хувийн тохироо тодорхойлох шинжилгээ – 114	90

					• Цусны хийн шинжилгээ – 470 • Тархи нугасны шингэний ерөнхий шинжилгээ – 32 Бактериологийн лабораторид нийт – 17640 шинжилгээ хийгдсэн байна. Үүнд: • Эрүүлзүйн агаар, арчдас – 125 • Цагаан хорхой илрүүлэх – 629 • Цусны ариун чанар – 90 • Биеийн шингэний бактериологи – 48 • Идээ шархны арчдас – 406 • Үтрээ, умайн хүзүүний арчдас – 2111 • Өтгөний бактериологи – 341 • Хамар залгиурын арчдас – 138 • Хөөмийн арчдас – 972 • Шээсний ариун чанар – 1860 • Эмэгтэйчүүдийн түрхэц – 9073 • Бактерийн антибиотик мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ – 1068 • Мөөгөнцрийн антибиотик мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ – 21 Молекул биологийн лабораторид нийт – 624 шинжилгээ хийгдсэн байна • Хүний папилома вирусын 28 хэв шинж тодорхойлох шинжилгээ – 91 • БЗХӨ-ний үндсэн 7 төрлийн үүсгэгч илрүүлэх шинжилгээ – 501 • Тархи нугасны шингэнд бактерт менингококкт халдвар илрүүлэх – 4 • Элэгний В вирусийн ДНХ тоолох – 9 • Элэгний С вирусийн РНХ тоолох – 11 • Элэгний D вирусийн РНХ тоолох – 8 Эмгэг судлалын лабораторид нийт 2401 хүний 6255 шинжилгээ хийгдсэн байна. Үүнд: • Цитологи – 538 хүний 554 шинжилгээ	
--	--	--	--	--	--	--

					• Аутопси – 6 хүний 174 шинжилгээ • Биопси – 1857 хүний 5527 шинжилгээ Эмнэлзүйн лабораторийн тусламж үйлчилгээний чанарын хяналтын тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд: Чанарын дотоод хяналт • Эмнэлзүйн лабораторийн хэсэг тус бүрт хяналтын ийлдэс, стандарт материал, өвчтөний материалд давтан хийсэн шинжилгээний дүн, тэдгээрийн статистик боловсруулалт, өдөр тутмын шинжилгээний дүнд хийх анализ ажиглалтын аргуудаар хийж байна. • Цусны дэлгэрэнгүй, биохими, цус бүлэгнэлтийн шинжилгээний дотоод хяналтыг өдөр бүр, иммунологийн шинжилгээний дотоод хяналтыг урвалж уусмал шинээр найруулсан үед, молекул биологийн хяналтын шинжилгээ хийх бүрт эерэг, сөрөг хяналтын материалаар, бактериологийн дотоод хяналтыг шинээр хийсэн тэжээлт орчинг цэвэр тэжээлийн термостатанд 24 цаг хийж ургалтыг хянаж, наацын болон серологийн шинжилгээний хяналтыг зэрэгцээ сорилын аргаар тус тус хийж гүйцэтгэж байна. • 04 сарын 10-ны өдөр 6Б-Нярайн тасгаас ирсэн биохимийн сорьц гемолиз болж үүсэх шалтгаан, сэргийлэх арга хэмжээний тухай хэлэлцэн центрифугит сорьц эргүүлэх хурдыг удаашруулж 3000 rpm эргэлт болгож тохируулав. Мөн 2025 оны 04 сарын 18-нд цусны сорьцонд гемолиз үүсэх шалтгаан, сэргийлэх зөвлөмжийг төвийн телеграмм группд	
--	--	--	--	--	--	--

					байршууллаа. • 2025 оны 06 сарын 06-нд Тархи нугасны шинжилгээний сорьцонд тавигдах шаардлага сэдэвт зөвлөмжийг байршуулав. • 2025 оны I улиралд Шинжилгээний өмнөх үе шатны үл тохирол 280, шинжилгээний үеийн үл тохирол 0, шинжилгээний дараах үеийн үл тохирол 0 бүртгэгдсэн байна. 1. Чанарын гадаад хяналт 2025 оны Үндэсний чанарын гадаад үнэлгээний дүн: - 7th MEQAS Coagulation – 94% - 27th MEQAS Chemistry – 80% - Цусны бүлэг, хувийн тохироо – оролцсон - Иммунологи – оролцсон - Бактериологийн шинжилгээний ЧГҮ – оролцсон Мөн Испани улсын биохимийн “PREVECAL” ЧГҮнэлгээнд сар бүр онлайнаар холбогдон оролцож байна. СХДНЭ-ийн Лабораторийн нэгдсэн тасагтай 2025 оны 01 сарын 22-нд, 03 сарын 19-нд, 04 сарын 25-нд, 05 сарын 22-нд лаборатори хоорондын ЧГҮ хийсэн ба 4 удаагийн лаборатори хоорондын чанарын үнэлгээний утга зөвшөөрөхүйц хэвийн байсан. Мөн Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгтэй b-HCG болон TSH шинжилгээгээр лаборатори хоорондын харьцуулалтын аргаар үнэлгээ хийсэн. Лаборатори хоорондын чанарын үнэлгээний утга зөвшөөрөхүйц хэвийн байв. 2025 оны 05 сарын 28-нд зохион байгуулсан ЧГҮнэлгээнд оролцов. Үүнд: - 8th Коагулограм	
--	--	--	--	--	---	--

						- 28th Биохими - 34th Гематологи - 23th Цусны бүлэг, хувийн тохироо - 3rd, 4th Шээсний шинжилгээ - 23th Иммунологи - Томуу болон SARS-COVID-ын нуклейн хүчил тодорхойлох ПГУ шинжилгээ 2. Лабораторийн - Чанарын баг - Эрсдлийн баг - Халдвар сэргийлэлт хяналтын баг - Гарын багийн гишүүдийг шинэчлэн, баг тус бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна.	
Зорилт 7. Эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог бэхжүүлж, бичил биетний тэсвэржилтийг тандах тогтолцоог сайжруулах							
7.1	Эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог бэхжүүлэх	0	2025	65	Эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагааг сайжруулахад шийдвэр гаргагчдын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлсэн байна.	Нийт тасаг нэгжүүдийн Халдварын сэргийлэлт хяналтын багийг томилон Халдварын сэргийлэлт хяналтын албанаас мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтыг тогтмол өгч хяналт тавин ажиллаж байна. ХСХАлбанаас дараах мэргэжилтэнгүүдэд чиглүүлэх сургалтыг олгодог • ЭНЭҮТөвд шинээр орсон эмч эмнэлгийн мэргэжилтэнгүүдэд • Гарын эрүүл ахуй аяны хүрээнд бүх дэмжин туслах албадуудад ажлын байран дээрх сургалтыг тус тус олгодог. Чиглүүлэх сургалтын сэдвүүд: ➤ ЭМС-ын А/537 тоот тушаалын 1-р хавсралтын дагуу гар угаах халдваргүйжүүлэх заавар ➤ 3-р хавсралтын дагуу эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар ➤ 6-р хавсралтын дагуу эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар	70

						➤ 7-р хавсралтын дагуу хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэх заавар ➤ 9-р хавсралтын дагуу тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээний заавар 2025 оны байдлаар нийт шинээр ажилд орсон 34 эмч эмнэлгийн мэргэжилтэнгүүд, Халдварын сэргийлэлт, хяналт, тандалтын албаны 15 ажилчдад, Төвийн хэмжээнд давхардсан тоогоор нийт 980 эмч, ажилчдад сургалтыг эхний хагас жилд 6 удаа зохион байгуулж ажилласан.	
7.2	Эрүүл мэндийн байгууллагын ажилтанг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах	1.0	2025	45	Халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан, эмнэлгийн тархвар судлаачийг багц цагийн сургалтад хамруулах хөтөлбөр, төлөвлөгөө, модуль боловсруулж батлуулсан байна.	Халдварын сэргийлэлт хяналтын алба нь 15 хүний бүрэлдэхүүнтэй. Албаны дарга-1, халдвар судлаач эмч-2, ариутгагч-7, угаагч индүүдэгч-6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Албаны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Төвийн халдвар хамгаалал, урьдчилан сэргийлэх, ажилчдын мэдлэгийг дээшлүүлэх, хяналт үнэлгээг тогтмол хийж ажиллаж байна. Энэ оны сүүлийн хагас жилд мэргэшүүлэх сургалтанд хамруулахаар төлөвлөсөн.	50
7.3	Эрүүл мэндийн байгууллагад тэсвэртэй бичил биетний халдвараас сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	-	2025	80	Харуулдан тандалтын бүх нэгжид тандалт хийж, хэвшсэн байна. Харуулдан тандалтын нэгжийн	Нян судлалын шинжилгээгээр үйлчлүүлэгчээс олон эмэнд тэсвэртэй бичил биетэн илэрсэн тохиолдолд нян судлаач эмч аюултай хариу мэдээллэх хуудсаар эмчлэгч эмч болон халдвар судлаач эмчид мэдээллэдэг. Нян судлалын лаборатори нь антибиотик мэдрэг чанарыг үзэж тус бичил биетэнд тохирсон антибиотикийг сонгон хариу арга хэмжээг авч тусгаарлан эмчилдэг.	100

					тандалт хийх журам шинэчлэн боловсруулж батлуулна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар: • Метициллин тэсвэртэй staphylococcus aureus /MRSA/-21 • ESBL-2 • Acinetobacter SPP-1 дээрх олон эмэнд тэсвэртэй бичил биетнүүд илэрсэн.	
Зорилт 8. Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлөх шинэ сорилт, болзошгүй цар тахал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах эрсдэлийн харилцааг олон салбарын оролцоонд тулгуурлан өргөжүүлэх							
8.1	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулах	-	2025	80	Эрсдэлийн харилцааны чиглэлээр сургагч багш бэлтгэсэн байна.	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх сургалтыг нийт 7 удаа зохион байгуулж 810 хүн, сурталчилгаа 32 удаа зохион байгуулж нийт 3000 ширхэг тараах материал бэлтгэн тараасан байна. Дараах цахим хуудсууд дээр 15 удаа мэдээлэл байршуулсан.Үүнд: ➢ Төвийн цахим хуудас, ➢ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➢ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➢ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➢ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➢ Буянт Ухаа-2 хороолол, ➢ Шүрт хотхоны групп, ➢ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 19710 хүн хандалт хийсэн. Нийт тасаг нэгжүүдийн Халдварын сэргийлэлт хяналтын багийг томилон Халдварын сэргийлэлт хяналтын албанаас мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтыг тогтмол өгч хяналт тавин ажиллаж байна.	70

					ХСХАлбанаас дараах мэргэжилтэнгүүдэд чиглүүлэх сургалтыг олгодог • ЭНЭҮТөвд шинээр орсон эмч эмнэлгийн мэргэжилтэнгүүдэд • Тус төвд шинээр суралцахаар ирсэн резидент эмч нарт • Төвийн нийт эмч, сувилагч, эх баригч, туслах сувилагч, үйлчлэгч нарт • Гарын эрүүл ахуй аяны хүрээнд бүх дэмжин туслах албадуудад ажлын байран дээрх сургалтыг тус тус олгодог. Чиглүүлэх сургалтын сэдвүүд: ➤ ЭМС-ын А/537 тоот тушаалын 1-р хавсралтын дагуу гар угаах халдваргүйжүүлэх заавар ➤ 3-р хавсралтын дагуу эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар ➤ 6-р хавсралтын дагуу эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар ➤ 7-р хавсралтын дагуу хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэх заавар ➤ 9-р хавсралтын дагуу тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээний заавар ➤ ЭМС-ын А/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хягдалын менежмент сэдвүүдээр тус бүр мэргэжлийн онцлогт нь тохируулж чиглүүлэх сургалтыг хийж байна. 2025 оны 5 сарын байдлаар нийт шинээр ажилд орсон 34 эмч эмнэлгийн мэргэжилтэнгүүд болон ажилчдад чиглүүлэх сургалтыг зохион байгуулж ажилласан.	
--	--	--	--	--	---	--


Нэгдсэн дүгнэлт	-	2025	Тайланг нэгтгэж хүргүүлсэн байна	2025 оны эхний хагас жилийн байдлаар халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний 8 зорилт, 17 үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлын гүйцэтгэл 66.7 хувьтай. Амьсгалын замын халдварт өвчний дэгдэлтийн үед яаралтай тусламжийн бэлэн байдлыг бүрэн ханган яаралтай тусламжийн тасаг, амьсгалын замын цочмог эмгэг судлалын тасгуудад нийтдээ 20558 хүүхдийг эмчилсэн байна. Нярайд хийх 24 цагийн доторх дархлаажуулалт 100 хувьтай. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг нийт 4 удаа зохион байгуулж нийт 198 хүн, сурталчилгааг нийт 15 удаа зохион байгуулж 1100 гаруй хүн хамруулж нийт 550ш боршуур тараасан байна.Өөрийн фэйсбүүк хаяг болон 21-р хорооны оршин суугчдын групп дээр нийт 12 удаа мэдээлэл тавьж хандалт авсан иргэний тоо 620 байна. Урд оны мөн үетэй харьцуулахад сургалт сурталчилгаа 15%-иар өссөн байна.	75
-----------------	---	------	----------------------------------	---	----

ХАВСРАЛТ:

Иргэд, үйлчүүлэгч нарт чиглэсэн мэдээлэл хийж байгаа нь: “Томуу, томуу төст өвчин”, “Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Гарын ариун цэвэр, хоолны хордлого урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр сурталчилгаа хийсэн байдал:



Амбулаторын дэлгэцээр “Сүрьеэгийн хавдраас урьдчилан сэргийлэх” видео контент бэлтгэн олон удаагийн давтамжтай үйлчлүүлэгч нарт хүргэсэн.



Сүрьеэ өвчин бүрэн эдгэрдэг.
Сүрьеэгийн эмчилгээ нь болгоно хугацаанд шууд хяналттай хийгдэх ёстой бөгөөд **таны уйгагүй, ухамсартай эм уултаас л шалтгаална.**

Эмчилгээний зарчим баримталснаар

- Өвчтөн төгс эмчлэгдэнэ
- Гэр булчинхандаа болон ойр орчимдоо халдвар тараахгүй
- Хүндрэл буурна
- Эмийн дасал үүсгэхгүй зэрэг ач холбогдолтой.

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ХЭРХЭН СЭРГИЙЛЖ ЧАДАХ ВЭ?

Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга

1. Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх хамгийн эхний үр дүнтэй арга нь **БЦЖК** вакцин юм. **БЦЖК** вакциныг анх төрсөн, эрүүл гуйцдаг нөхцөлд 24 цагийн дотор 1 удаа тарьж дархлаажуулна.
2. Өрөө тасалгаагаа байнга агууржуулж нар салхи оруулах, чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийж байх нь чухал.
Нарны туяа сүрьеэгийн нөхцөл хурдан устгадаг.
3. Сүрьеэгээр өвчлөхөөс сэргийлэх арга нь биеийн эсэргүүцлийг сайжруулах Үүнд: Хувь хүн өөрийн дархлаагаа сайжруулахын тулд чанарлаг хоол хүнсээр хооллох, биеийн тамир хөдөлгөөнийг эрхэмлэх, ажил амралтын дэглэм зөв тохируулж амрах, хорт зуршил хэрэглэхгүй байх явдал.



Вакцины хадгалалт тээвэрлэлт:



Эмч ажилчдад “ЭМС-ын 536, 537 тоот тушаал”, “Эмнэлгийн хог хаягдлын менежмент”, “Халдварт өвчний үеийн бэлэн байдал” сэдвүүдээр сургалт хийж байгаа нь:



Харьяа нутаг дэвсгэрийн сургуулиудад хийсэн сургалтын үйл ажиллагаанууд



Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчдад “Халдварт өвчнөөс сэргийлэх, тандах, хяналт тавих үйл ажиллагаа” сэдэвт сургалт:

